

### ХАР ТАМХИНЫ ДАЙНЫ ТУХАЙ (Архивийн материалаар)

Л. Лувсанчүлтэм

Өнгөрсөн XIX зууны эхнээс баруун Европын капиталист гүрнүүд ба Хятад орны хоорондын харилцаа нэлээд өргөжсөн бөгөөд мөн зууны дундуур энэхүү харилцаа нь Манж Чин гүрэнд ноцтой аюул болон хувираад Европын капиталистууд Хятад орныг чухамхүү эдийн засгийн талаар эрхшээлдээ оруулж эхэлсэн байна. Капиталист гүрнүүдийн худалдаачид Хятадад «Ярши тамба» гэдэг хар тамхийг их хэмжээгээр оруулдаг болсон бөгөөд тэр нь хүн ардын бие махбодыг хордуулж, ажил хөдөлмөрийн чадваргүй болгодог асар их хор хөнөөлтэй зүйл юм. Иймд манжийн засаг захиргаанаас тус оронд хар тамхи хэрэглэхийг эртнээс нааш хориглосоор ирсэн боловч хятад иргэдийн дотор тэр тамхийг татах явдал өргөн дэлгэрээд улмаар Өвөр Монголчуудын дунд хятад хүмүүсийг дууриан хар тамхи татагч хүн олшрон, ажлын чадвараа алдаж, амьдрах аргагүй болон хоосорч сүйрэх зэрэг муу явдал халдварлаж байсан учир Манжийн Засгийн газраас хар тамхи татахыг хатуу чанга хориглож, түүнийг гадаадаас оруулах, дотоодод тариалахыг үүрд зогсоосон тухай тусгай хууль гаргаж, бүх орон даяар зарласан бөгөөд хэрвээ аль нэгэн ард иргэд хууль зөрчин хар тамхи татсан хэрэг илэрвэл тэр дор нь барин авч толгой огтлох хүртэл хүндээр шийтгэж байв. Гэтэл Европын капиталистууд манжийн энэ хуулийг огт тоомсорлохгүй хар тамхиа үргэлжлэн «нууцаар» оруулж байжээ. Жишээ нь: Англиас Хятадын өмнөд районд жил бүр 34000 илүү хайрцаг (хайрцаг бүр 50 кг) хар тамхи оруулж байв.<sup>1</sup>

Хар тамхины худалдаатай тэмцэх манжийн засгийн газрын төлөөлөгч Юан Чуан<sup>2</sup> гэгч англичуудын энэ ажиллагааг таслан зогсоохын тул угтан тосч сэрэмжлэн байсан бөгөөд тэрээр 1839 онд нэг удаа тэнгисийн эрэгт хүрч ирсэн Английн худалдааны онгоцноос 2000 илүү хайрцаг хар тамхи хураан аваад шатааж устгажээ.<sup>3</sup> Энэ болсон хэрэг явдлыг Английн засгийн газар шалтаг болгон 1840 онд Хятадын эсрэг дайн хийв.

Цэрэг, эдийн засгийн хувьд ихэд хоцрогдсон манж гүрэн даруй ялагдаад Англид тэнгисийн боомтуудаа нээн өгч худалдаа хийлгэх хөнгөлттэй эрх олгосон ба дайны торгууль төлсөн байна. Энэ үеэр манжийн хаан төрийг эсэргүүцсэн Хятадын ард түмний Тайпингийн бослого өрнөж, Чин гүрний дотоод байдал хүндрэн, түүний засгийн газар сандран тэвдэж байсан цаг тул Англи, Франц хоёр хамтаар тухайн байдлыг ашиглан хятадаас олж авсан эрхээ улам өргөтгөн, хятадын гүн дэх районд нэвтрэн орж сайхь хар тамхи болон бусад бараагаа чөлөөтэй худалдаж байх эрхтэй болох гэж ёс бусчлан аашилсан учир бас дахин муудалцаж 1855-1858 онд хар тамхины хоёрдугаар дайн болсон бөгөөд манжийн цэрэг мөн л бут цохигдсон тул Чин гүрэн буун өгч, гадаад гүрний худалдаа хийхэд зориулан тэнгисийн хэд хэдэн боомтыг шинээр нээн өгч

<sup>1</sup>УТТА, Ф I, ХН 361.

<sup>2</sup>Юан Чуан бол монгол гаралтай хүн гэсэн мэдээ бий.

<sup>3</sup>УТТА, Ф. I, ХН, 361.

бас Хөх мөрнөөр гадаадын хөлөг онгоц аялахыг зөвшөөрчээ.

1860 онд Англи, Франц хоёр Хятадаас урьд олсон эрх ашигтаа ханаж цадахгүй харин улам даварч, гуравдахь удаагаа дайн хийж Тяньзинг өөрсдийн худалдааны хот болгон нээлгэж авчээ. Ингэж Манж гүрэн Их Британи ба Францтай тулалдсан 3 удаагийн дайнд ялагдсан цагаас эхлэн Манж гүрний гол төв болж байсан Хятад нь даруй империалистуудын хагас колонийн орон болон хувирч байв.

Эдгээр хэрэг явдлыг түүхэнд «Хар тамхины дайн» хэмээн нэгэнт нэрлэдэг билээ.

В. И. Лениний бичсэн нь: «Европын капиталистууд зөвхөн баяжихын төлөө хятадад ирдэг... ард түмнийг мунхруулагч хар тамхи худалдаалах эрх олж авахын тулд Хятадтай дайн хийдэг»<sup>4</sup> гэжээ. Хар тамхины II дайн болж байсан үед Лифаньюаниас<sup>5</sup> Монголын Их Хүрээ, Улиастай хотод зарлан мэдэгдсэн нэгэн бичигт өгүүлсэн нь: «Англи, Францын цэрэг манай Гуань-дун мужид цөмрөн оров. Эдүгээ бүх мужийг алдсан бус боловч, мөн мужийн амбан Англид дэнж болон автсан»<sup>6</sup> гэжээ. Эдгээр дайны жилүүдэд манжийн харъяа бүх төв, орон нутгийн газраас байлдаж байгаа цэрэгт туслах эд материал явуулж байв. Энэхүү хар тамхины дайн нь асар хол өмнөх далай тэнгисийн эрэгт болсон авч манжийн ноёд тэрхүү алс холыг ер харгалзахгүй халхчуудын мал хөрөнгийг дайнд зориулан албадан авч нилээд хэмжээгээр сүйтгэсэн байна. Жишээлэхэд: 1842 онд тэр үеийн халхын Түшээт хан, Цэцэн хан аймгаас 2200 агт морь, 4400 хонийг<sup>7</sup> урьд хожид авчээ. Үүнээс гадна манж нар энэ дайнд монголчуудаас гагцхүү мал сүрэг аваад зогсоогүй, харин олон мянган монгол цэрэг дайчлан газар газар цуглуулж Англи, Францын цэрэгтэй байлдуулахаар бэлтгэн зэхэж байв. Жишээ нь: 1860 онд халхын дөрвөн аймгаас 4 мянган морин цэрэг Өвөр Монголын хошуудаас 3000 морин цэрэг гаргуулан тус тусын нутагт сургууль үйлдүүлэн байв.<sup>8</sup> Чингээд Түмэд баруун хошууны 1000 цэргийг түшмэл Ванчинбал<sup>9</sup> гэгчээр захируулан мордуулаад Английн хөлөг онгоцноос буусан хурц зэвсэг бүхий нэгэн анги цэрэгтэй байлдуулсанд монгол цэрэг их л зоригтой тулалдаж амжилт гаргасан гэдэг домог яриа одоо хүртэл байсаар байдаг юм. Тэр домогт:

«Ванчинбалын баатрууд, баруун далайн хулгайг байлдан дараад хөдөө талын хүдэр монголын хүчийг үзүүлсэн билээ» гэж байдаг. Үүнээс үзвэл манжчууд өөрийн сүр хүчин доройтох үедээ гадаадын империалистуудын эсрэг дайнд монголын морьт хороог ашиглах явдал нэг биш удаа гарч байсан бөгөөд тухайн үед монгол цэргүүд их баатарлаг зоригтой байлдаж байсан нь дээрх баримтаас тодорхой байна. Гэвч Манжийн эзэн хаад монгол цэргийг хэсэгчлэн хувааж харийн дайсны халдлагыг дарахад ашиглаж байсан нь гүрний нутаг дэвсгэрийг хамгаалахад байлдааны чадварыг ашиглахад оршиж байснаас гадна бас монголын цэргийн нийтлэг хүчирхэг чадварыг аажим сулруулах, тэгснээрээ монгол угсааны хүн ардыг манж гүрний эсрэг тэмцэлд босгохгүй байлгах гэсэнд оршиж байв.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд хар тамхины дайны жилүүдэд нийт монголоос олон тооны мал сүрэг албадан авч, ард түмний аж ахуйг хохируулсан ба олон мянган идэр эрчүүдийг цэрэгт татаж дэмий чирэгдүүлсэн байна.

<sup>4</sup>В. И. Ленин, зохиолууд IV боть, 372-р тал.

<sup>5</sup>Монгол, Төвд, Хотонгийн асуудал эрхэлсэн яам буюу колонийн яам.

<sup>6</sup>УТТА, Ф. I, ХН 167, дэнж гэж барьцаа гэсэн үг

<sup>7</sup>УТТА, Ф. I, 4-26—216.

<sup>8</sup>УТТА, Ф. I, 4-26—270.

<sup>9</sup>Ванчинбал (1745—1747), Түүхч зохиолч Инжинаашийн эцэг.

Энэ өчүүхэн баримт нь манжийн колоничлолын уршгаар монголчуудад учирсан хэлмэгдлийн нэг хэсэг даруй мөн. Иймээс тухайн үеийн байдлыг харуулсан архивын манж хэлний хомс чухал материалыг үндэслэн энэ өчүүхэн зүйлийг бичив.